



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 7/631

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн
төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 48 дугаар зүйлийн 48.2.6, 48.2.7, 48.2.9, Засгийн газрын 2023 оны "Журам батлах тухай" 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны "Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай" А/258 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны "Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай" А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Хөвсгөл/ ХӨАХААГ/20240102163 дугаартай төсөл арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Хөвсгөл, Арбулаг, Бүрэнтогтох, Галт, Тариалан, Түнэл, Улаан-Уул/ багц-8-д 74,272,000 (Далан дөрвөн сая хоёр зуун далан хоёр мянган) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Сүүхүнгий" ХХК -ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. "Сүүхүнгий" ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, ажлын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, ажлын үе шатны хяналт хэрэгжүүлэх этгээдтэй гэрээ байгуулах дүгнэх, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх чиг үүрэг бүхий "Захиалагчийн төлөөлөгч"-өөр аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-г томилж, ажил, үйлчилгээ хүлээн авах, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч, ажлын хэсгийн ахлагч:

Э.Улам-Өсөх

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Ажлын хэсгийн гишүүд:

П.Хажидмаа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Мэдээлэл технологи, дотоод сүлжээ
хариуцсан ажилтан)

Б.Цэнддэлгэр

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
өмчийн бүртгэл ашиглалт хариуцсан
ахлах мэргэжилтэн)

Э.Батхуяг

("Сүүхүнгий" ХХК-ийн захирал)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Б.Баярмаа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын

6712012082


d/A4

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
Сум, багийн бодлого үйл ажиллагаа,
дотоод хяналтыг зохион байгуулах
ахлах мэргэжилтэн)

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж / Хөвсгөл / ХӨАХААГ/20240102163 дугаартай төсөл арга хэмжээний гүйцэтгэгч сонгох тендер шалгаруулалтын ЗДТГ-ын тоног төхөөрөмж / Хөвсгөл, Арбулаг, Бүрэнтогтох, Галт, Тариалан, Түнэл, Улаан-Уул / багц-8-г нийлүүлэхээр гүйцэтгэгч сонгох гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, гэрээний хэрэгжилтийг хангах, барааг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч, ажлын хэсгийн ахлагч (Э.Улам-Өсөх)-д, захиалагч, тендер оролцогчийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон Худалдан авах ажиллагааны газрын архивд шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Даваасамбуу)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ТӨМӨРБААТАР